

# Багануур дүүрэг "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа

2022 оны 7-р сар



© В.Эрдэнэ

# Агуулга

Удиртгал ба аргачлал .....	1
Мэдээллийн дүн шинжилгээ.....	2
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	2
1.2 Ирсэн иргэд.....	3
1.3 Явсан иргэд.....	3
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	4
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	5
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	6
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	10
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	14
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	15
1.10 Хүүхэд болон боловсрол.....	16

# Удиртгал ба аргачлал

## Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Багануур дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол гэх мэт. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан.

Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

## Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




# 1. Мэдээллийн дүн шинжилгээ - Багануур дүүрэг

## 1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны гуравдугаар сар) Багануур дүүрэгт 30,124 иргэн, 7,890 өрх бүртгэгдсэн ба үүнээс дөчин есөн хувь нь эрэгтэй, 51 хувь нь эмэгтэй байна. Хүн амын 33 хувь нь насанд хүрээгүй хүүхэд байснаас 10 хувь нь 0-5 настай, 24 хувь нь 6-17 настай хүүхэд байна. Хүн амын 62 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 5 хувийг өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 702 хүн архаг эсвэл хүнд өвчтэй (хүн амын 2.3%), 207 эмэгтэй жирэмсэн (эмэгтэйчүүдийн 1.3%) гэж бүртгэгдсэн байна.

Багануур дүүрэг нь нийт таван хороо, 34 хэсэгтэй. Хамгийн их хүн амтай нь 1-р хороо, хүн амын 32 хувь нь амьдардаг бол 5-р хороо 27 хувь, 3-р хороо 21 хувь нь амьдарч байна.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



## 1.2 Ирсэн иргэд<sup>2</sup>

2021 онд Багануур дүүрэгт нийт 588 өрх буюу 1,876 иргэн иржээ. 2021 онд Улаанбаатар хотод нийт ирсэн иргэдийн дөнгөж 1.6 хувь нь Багануур дүүрэгт бүртгэгдсэн ба үүний дийлэнх нь 5-р хороо (54%), 1-р хороонд бүртгэгдсэн байна (36%). Багануур дүүрэгт ирсэн гол шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (33%), боловсрол (21%), эдийн засгийн шалтгаан (15%) байв.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)




## 1.3 Явсан иргэд

2021 онд Багануур дүүргээс нийт 1,371 өрх буюу 4,464 иргэн явсан. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд аль нэг дүүргээс явсан нийт иргэдийн 5.2 хувь нь Багануур дүүргээс явсан гэж бүртгэгдсэн байна. Хамгийн их явсан иргэд бүртгэгдсэн нь 5-р хороо (63%), дараа нь 3-р хороо байна. Багануур дүүргээс явах болсон үндсэн шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (39%) байна.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




<sup>2</sup> Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршлаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.


## 1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Багануур дүүргийн хэсгүүдийн 50 хувьд нь зонхилж буй хөдөлмөр эрхлэлтийн салбар нь уул уурхай, олборлох болон бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэж бүтгэгджээ. 1-р хороонд уул уурхай, олборлох болон бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хамгийн өндөр хувьтай (75%) байсан бол 4-р хороо (67%), 5-р хороо (50%), 3-р хороо (38%) байна. Мөн 2-р хороонд уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлж буй иргэд бүртгэгдээгүй бөгөөд 75 хувь нь өрхийн хөдөлмөр эрхлэлт (гэрийн ажил) хийж байна гэж мэдээлсэн байна. Нийт 19,059 хүн (дүүргийн хүн амын 63%) уул уурхайн салбар давамгайлсан хэсэгт амьдардаг, тиймээс Багануур дахь хөдөлмөр эрхлэлт нь нийслэлийн дунджаас ихээхэн ялгаатай байна. Нийслэлийн хэмжээнд уул уурхай болон бусад аж үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэлтийн нөхцөл байдал нийт хэсгүүдийн зөвхөн 6 хувь байна.


Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь %)




Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл, хороогоор (хэсгийн эзлэх хувь)

Нийт	Хороо #1
56%	88%
Төрийн байгууллага	Төрийн байгууллага
Хороо #2	Хороо #3
50%	50%
Хувийн хэвшил	Төрийн байгууллага
Хороо #4	Хороо #5
67%	50%
Төрийн байгууллага	Хувийн хэвшил

Багануур дүүргийн хэмжээнд 18-64 насны 8,061 хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 44 хувийг эзэлж байна. Энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд улсын дунджаас (30%) 14 оноогоор илүү байна. 1-р хороо (48%), 5-р хороо (43%), 4-р хороо (42%), 3-р хороо (41%) хөдөлмөр эрхлээгүй хүн ам бүртгэгдсэн бол 2-р хорооны хувьд хамаагүй бага (15%) байна. Гэхдээ 2-р хороонд Багануур дүүргийн хөдөлмөрийн насны хүн амын ердөө нэг хувь нь (168 хувь хүн) амьдардаг тул энэ мэдээлэл ач холбогдол багатай харагдаж байна. Энэ дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин өндөр байгаа нь Багануур дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн салбар хязгаарлагдмал байгаатай холбоотой байх магадлалтай тул нарийвчлан судлах нь чухал: Багануур дүүргийн нийт хэсгүүдийн 50 хувьд нь уул уурхай, олборлох салбар зонхилж (хотын хэмжээнд дунджаар 7%) байгаа бөгөөд Мал маллах, хөдөө аж ахуй эрхлэлт, ойн аж ахуй эрхлэлт хөдөлмөр эрхлэлтийн дараах үндсэн салбар (хотын хэмжээнд дунджаар 12%) гэж Багануур дүүрэгт мэдээлсэн байна.

Багануур дүүргийн хэмжээнд хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэлт ердөө 26 хувийг эзэлдэг бол 56 хувьд нь төрийн байгууллагад ажилладаг гэж мэдээлсэн байна. Энэ нь нийслэлийн түвшний дунджаас ихээхэн ялгаатай байгаа бөгөөд Багануур дүүрэг дэх иргэдийн гуравны хоёроос илүү хувь нь хувийн хэвшилд хамгийн их хөдөлмөр эрхэлдэг гэж мэдээлжээ. Иргэдийн дөнгөж 15 хувь нь төрийн албанд голчлон ажиллаж байна. Иймд Багануур дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь маш өндөр байгаа нь хувийн хэвшлийнхэнд боломж хомс байгаатай холбоотой байх магадлалтай юм.


### 1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын бууралт болон хоол, хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар мэдээлэл нэгтгэгчдийн ажиглалтыг авч үзэх замаар төлбөрийн чадварыг судалсан болно.

Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байгаа хэсгүүдийн 26 хувь нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногт өрхүүдийн хүнсний хэрэглээ буурсан тухай санаа зовниж байгаа талаар мэдээлсэн нь Багануур дүүргийн 7,913 хүнийг хамраад байна. 2-р хороо хамгийн их эмзэг байгаа талаар мэдээлснээс нийт хэсгүүдийн 50 хувьд нь хоол, хүнс хүрэлцэхгүй байдалтай байна.

Нийт хэсгүүдийн 44 хувь нь мэдээлэл нэгтгэхээс дөрвөн долоо хоногийн өмнө айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай сонссон гэж мэдээлсэн нь нийт 12,325 хүн амыг хамраад байна. Энэ үзүүлэлт нь нийслэлийн хэмжээнд дунджаар 10 хувиар өндөр байгаа нь дүүргийн хэмжээнд хүнсний хүртээмжтэй холбоотой байна гэдгийг харуулаад байна. Хамгийн эмзэг нь 2-р хороо байсан бөгөөд тус хорооны бүх хэсгийн мэдээлэл нэгтгэгчид айл өрхүүд хүнсний хэрэглээгээ бууруулж байгаа тухай мэдээлсэн байна.

Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байгаа хэсгүүдийн 12 хувьд нь мэдээлэл нэгтгэхээс өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд бараг хэний ч орлого буураагүй гэж мэдээлсэн бол үлдсэн 71 хувьд нь хүн амын талаас бага хувийн орлого (25%) буурсан гэж мэдээлсэн байна. Гэсэн хэдий ч, илүү чухал дүгнэлт бол хэсгүүдийн 15 хувьд өрхийн орлого мэдэгдэхүйц буурсан, үлдсэн 3 хувь нь орлогын эх үүсвэрийн хагасаас илүү (75%) хувийг алдсан гэж мэдээлсэн нь нийт Багануур дүүргийн 5,145 хүн амыг хамарч байна. Мөн дүүргийн нийт хүн амын 18% хувь нь бүх орлогын эх үүсвэрийн 50 хүртэлх хувийг алдсан гэж мэдээлсэн бөгөөд энэ нь дүүргийн хүн амын 4,159 хүнийг хамарч байна.

Хүнсний аюулгүй байдал (хэсгийн эзлэх хувь)


### Хүнсний хэрэглээ хангалтгүй байгаад санаа зовних



### Хүнсний хэрэглээгээ багасгасан




Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



### 1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Багануур дүүргийн хэмжээнд хамгийн их тулгамдсан асуудал бол санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой. Хамгийн их мэдээлсэн тулгамдсан асуудал бол дүүргийн хэмжээний хөдөлмөр эрхлээгүй хүн ам (хэсгүүдийн 50% -д мэдээлсэн), орлого хангалтгүй (24%), өр зээл (18%) байна. 2-р хороонд хөдөлмөр эрхлээгүй хүн амтай холбоотой санаа зовнил хамгийн өндөр мэдээлэгдсэн бөгөөд энэ асуудлыг бүх хэсгүүдэд мэдээлжээ.

Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




Багануур дүүрэгт иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний хүртээмж бага байгаа салбар нь эрүүл мэндийн үйлчилгээ (35%), амьжиргаа, ажлын байр, орлого бий болгох боломж хомс (21%), болон авто машины зогсоол хүрэлцээгүй (18%) гэсэн байв. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжгүй байдал нь 2-р хорооны 75 хувьд нь байгаа бол 1-р хороонд амьжиргаагаа бий болгох боломжийн хүртээмжгүй байдал хэсгүүдийн 38 хувьд нь бүртгэгджээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй гол бэрхшээл нь гудамж, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжид аюулгүй нэвтрэх дэд бүтэц дутмаг (47%), дараа нь тусгайлсан тээврийн хэрэгсэл бүхий үйлчилгээ байхгүй (41%) гэж мэдээлсэн байна. Мөн түүнчлэн зориулалтын сэргээн засах эмнэлэг, сувилал байхгүй байна гэж нийт хэсгүүдийн 9 хувь нь мэдээлжээ.




Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдал, хороогоор (хэсгийн эзлэх хувь)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)


Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## 1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

### УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ХООЛ, ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## 1.7 Дэд бүтэц, үйлчилгээ, тээвэр

### ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС

Хүнсний бус бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бус бүтээгдэхүүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ИНТЕРНЭТ

Интернэтэд холбогдоогүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Интернэтийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### УХААЛАГ УТАС

Ухаалаг утас ашигладаггүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)



Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)







## 1.8 Ногоон байгууламж



Мэдээлэл нэгтгэгчээс өөрийн хэсгийн нутаг дэвсгэр дээрх ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн чанарыг нэгээс тав хүртэл, (нэг нь маш муу, тав нь маш сайн) оноогоор үнэлхийг хүссэн. Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар Багануур дүүргийн хэмжээнд 2.9; айл өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар 3.1; хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар 2.7 гэсэн үнэлгээ авсан байна.

Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар (хэсгийн эзлэх хувь)  
Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




## 1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн


Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Багануур дүүргийн хэмжээнд замын хөдөлгөөний хамгийн гол тулгамдсан хоёр асуудал бол авто машины зогсоол, хүүхдийн тоглох нийтийн талбай дутмаг (аль аль нь хэсгүүдэд 29%-тай бүртгэгдсэн) байв. Бусад мэдээлэгдсэн асуудлууд нь эвдэрсэн зам, замын тэмдэг дутмаг, авто машины хөдөлгөөний чимээ шуугиан, тээврийн хэрэгсэл хэт хурдан явдаг, дугуйн зам дутагдалтай гэж мэдээлсэн байна. Автомашины зогсоол дутмаг, хүүхдүүд тоглох талбай дутмаг нь 4-р хороонд хамгийн их бүртгэгдсэн (аль алина хэсгүүдийн 50%-д нь) бүртгэгджээ.



© Y.Одбаяр

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.


Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

### 1.10 Хүүхэд ба боловсрол



Багануур дүүргийн хэмжээнд 0-5 насны 610 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй байгаагаас (тухайн насны хүн амын 20%), 6-17 насны 45 хүүхэд (тухайн насны хүн амын 1%) сургуульд хамрагдаагүй байна. Энэ дүүрэгт боловсролд хамрагдаагүй түвшин хотын дунджаас бага буюу 0-5 насны хүүхдүүдийн хувьд 10 пунктээр, 6-17 насныхны хувьд 2 хувиар бага байв. 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин хамгийн өндөр нь 2-р хороонд (46%) байсан бол 6-17 насны хүүхдүүд хамгийн их боловсролд хамрагдаагүй нь 5-р хороонд (1.2%) байв.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал өөрсдийн хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Багануурын хэсгүүдийн 79 хувь нь боловсролтой холбоотой ямар ч асуудал гараагүй гэж хариулсан бол 15 хувь нь сургууль хүртэлх зай хэт хол байна гэж хариулжээ. Дүүргийн хэмжээнд хүүхдүүдтэй холбоотой хамгийн их бүртгэгдсэн хоёр асуудал бол хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх секц, дугуйлан дутмаг (хэсгүүдийн 29%), эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал (29%) байсан юм.

Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)



Хүүхдэд тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

